



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/141

Улаанбаатар хот

**“Эхийн алдар” одонгоор шагнуулах  
эхчүүдийг шагналд уламжлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 62.1.1, 66.1, дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 13 дугаар зарлигаар батлагдсан “Эхийн алдар одонгоор шагнах тухай журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн харьяат олон хүүхэд төрүүлж, өсгөн “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонгийн болзол хангасан эхчүүдийн нэрийн жагсаалтыг нэгдүгээр, “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонгийн болзол хангасан эхчүүдийн нэрийн жагсаалтыг хоёрдугаар, “Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулах эхчүүдийн хүүхдүүдийн мэдээллийг хавсралтаар тус тус баталсугай.

2.Хавсралтад дурдсан “Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулах эхчүүдийн материалыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ